

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ  
БАРИМТЛАЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ  
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2019 оны 04 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Сүхбат**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболд, А.Сүхбат, О.Батнасан, Х.Болорчулуун, Б.Энх-Амгалан, Л.Мөнхбаатар нараас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд гадаргын ба газрын доорх усны нөөцөөс хамаарч түүний ашиглалт, хэрэглээний эрэмбэ тогтоох, ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан эсхүл хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө учруулсан тохиолдолд ус ашиглах эрхийг хязгаарлах, цуцлах, цэнгэг усны ордыг аж үйлдвэрлэл болон уул уурхайн зориулалтаар ашиглахыг хориглох, усны хомсдолын түвшинг тогтоох аргачлалыг батлах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх зэрэг харилцааг зохицуулахаар тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.


Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат хууль батлагдсанаар гарах үр дагавруудыг тооцох, өмчийн болон хүний эрхийг хамгаалах асуудалтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгох, мэргэжлийн яамдыг оролцуулан ажлын хэсэг байгуулж нухацтай хандах, Улсын Их Хурлын гишүүн А.Сүхбат хөвд, цөөрөм байгуулах замаар цас, борооны усыг нөөцлөх, газрын гүний усыг хамгаалах олон улсын туршлагыг судалж хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ ялын бодлогоор хавтгайруулан шийдвэрлэх нь сөрөг үр дагавар үүсч болзошгүйг анхаарах, усны ашиглалт, хэрэглээний эрэмбэ тогтоохдоо хүнсний үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн Б.Батзориг мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн усан хангамжид анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Л.Элдэв-Очир хуулийн төслийг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль болон бусад хуультай уялдуулах, хууль хэрэгжсэнээр аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрөл, нөхөн төлбөрийн асуудал үүсэх эсэх, Засгийн газар хуулийн төслийг дэмжих боломжгүй гэснийг хууль санаачлагчид анхаарах нь зүйтэй гэсэн саналыг тус тус гаргасан бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалыг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**Л.ЭЛДЭВ-ОЧИР**